

БАТЛАВ:



МУИС-ИЙН СУРГАЛТ, ОЮУТАН ХАРИУЦСАН
ДЭД ЗАХИРАЛ Д-Р Б.ОЧИРХУЯГ

2018-2019 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН МУИС-ИЙН ОЮУТНЫ
УРЛАГИЙН ИХ НААДМЫН УДИРДАМЖ

ЗОРИЛГО:

1. Сонгодог, ардын уламжлалт болон орчин үеийн урлагаар дамжуулан оюутан залууст амьдарлын эерэг, зөв үнэлэмж төлөвшүүлэх.
2. МУИС-ийн урлагийн авьяастай оюутан залуучуудыг шалгаруулж МУИС-ийн оюутны нэгдсэн концертыг бүрдүүлэх.

ҮР ДҮН, АЧ ХОЛБОГДОЛ:

1. МУИС-ийн оюутны урлагийн баг, хамтлагуудыг бэлтгэх
2. Оюутны урлаг, уран сайхны боловсролыг дээшлүүлэх

СЭДЭВ: “Хотын соёл гэж юу вэ?”, “МУИС-ийн соёл” гэж юу вэ? тэмцээнд оролцогч баг хамт олны нүдээр их сургуулийн хамт олны соёл гэж юу вэ?

ХАМРАХ ХҮРЭЭ: МУИС-ийн бакалаврын түвшний оюутнууд хамрагдах

ХУГАЦАА: 2019.03.30 нд 09:00 цагт

ХААНА: Улаанбаатар чуулгын концертын их танхимд

АЛБАН ЁСНЫ НЭЭЛТ: 12:00 цагаас эхлэх МУИС-ийн захиралууд нээлтэнд оролцох үг хэлэх

- МУИС-ийн захирал Д-р Я.Төмөрбаатар
- МУИС-ийн дэд захирлууд болон бүрэлдэхүүн, салбар захирлууд оролцох

ЗАВСАРЛАГА ЧӨЛӨӨТ ҮЗҮҮЛБЭР: МУИС-ийн Оюутны холбоо хариуцан зохион байгуулах 13:30-14:00 цагт


ШАГНАЛ ГАРДУУЛАХ ЁСЛОЛЫН АЖИЛЛАГАА: 2019.03.30-ны 17:30-18:00 цагт

ЗОХИОН БАЙГУУЛАГЧИД:

- МУИС-ийн Оюутан, төгсөгчийн хэлтэс
- МУИС-ийн Оюутны холбоо хамтран зохион байгуулах

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:

- Ур чадвар
- Бэлтгэл, бичлэг болон хөгжмийн зэмсэг, ая шаардлага хангасан байдал
- Тайзны соёл, хувцаслалт
- Бэлтгэл зохион байгуулалт, найруулга агуулга **сайн байх**




ХӨТӨЛБӨР: Урлагийн наадам нь нийт 7 төрлөөр явагдана. Үүнд:

- **Мэндчилгээ** /“Хотын соёл гэж юу?”, “МУИС-ийн соёл” гэж юу вэ? тэмцээнд оролцогч баг хамт олны нүдээр их сургуулийн хамт олны соёл гэж юу вэ? гэсэн агуулгын хүрээнд 4-6 минут өгөгдсөн хугацаанд багтаасан байх/
- **Гоцлол эсвэл хоршил хөгжим** /3-5 минут/
- **Хамтлаг бүжиг** /цэнгээнт 5 минутаас ихгүй байх, 8 хос 16 гишүүнтэй байх/
- **Гоцлол дуу** /3-5 минут сонгодог, эстрад, бусад.../
- **Ардын болон язгуур урлаг** /3-5 минут хөөмэй, исгэрээ, бие биелгээ, магтаал, тууль гэх мэт язгуур үзүүлбэрүүд байх багууд 10-с илүүгүй оролцогчтой байна.
- **Хамтлаг дуу** /3-5 минут сонгодог, эстрад, бусад.../
- **Хамтлаг бүжиг чөлөөт** /4-6 минут, багийн нийт гишүүд 15-аас илүүгүй оролцогчтой байна./

ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- МУИС-ийн оюутан байх
- Салбар сургуулийн “Оюутны зөвлөл”-дөө оролцох төрөл үзүүлбэрээ урьдчилан мэдэгдэж бүртгүүлсэн байх
- Удирдамжинд заасан дагуу хугацаа, ая, хөгжим, хувцас тайзны жижиг хэрэгсэл бусад бэлтгэлээ урьдчилан хангасан байх
- Үзүүлбэр тодорхой, ойлгомжтой тоглолтын ерөнхий зохиомжид нийцсэн байх
- Урлагийн тоглолт үзүүлбэрийн үед шүүгчид, бусад оролцогчид, хамт олноо хүндэтгэн оролцох
- Үзүүлбэр эхлэхээс өмнө багийн бэлтгэлийг хангаж байраа эзэлсэн байх
- Багууд мэдүүлгийнхээ дагуу оролцох
- Шүүгчид, зохион байгуулагчдын гаргасан шийдвэр үнэлгээг хүлээн зөвшөөрч соёлтой оролцох

- Баг тус бүр өөрийн багийн оролцогч гишүүд болон багийн нийт гишүүдийн нэрс, үзүүлбэрийн нэрийг урьдчилан мэдүүлсэн мэдүүлэгийг 2019.03.28-нд 16:00 цагаас өмнө хичээлийн 2-р 200 тоотод ирүүлсэн байх.
- Багийн мэдүүлэг урьдчилан ирүүлээгүй баг хамт олны багийн нийлбэр онооноос 2 бүхэл оноо хасна.



ДҮГНЭХ, ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ:

- Урлагийн наадмыг мэргэжлийн шүүгчид дүгнэж шалгаруулна.
- Оноог нийтэд ил тод нээлттэй өргөж танилцуулах бөгөөд шүүгч тус бүр 1-5,5 оноогоор дүгнэнэ.
- Үзүүлбэр тус бүрт тайзны соёл, хувцаслалт баг хамт олны зохион байгуулалт зэргийг харгалзан үзэж дүгнэнэ.
- Үзүүлбэр тус бүрийг заасан хугацаанд явагдаж байгаа эсэхэд хяналт тавих хөндлөнгийн шүүгч ажиллах бөгөөд хугацаа хэтэрсэн тохиолдолд оноог үзүүлбэрээс хасч дүгнэх
- Урлагийн наадамд оролцогч баг хамт олон 03-р сарын 28-ний өдөр 15:00 цагт 2-р байрны 200 тоотод багийн ахлагч нар цугларч шалгаруулалтын хуваарь дарааллыг суглаж тогтооно. /Сугалаанд оролцогч багуудын төлөөлөл байхгүй, оролцох боломжгүй тохиолдолд сугалаад үлдсэн дугаарыг шууд тохируулахыг анхаарна уу./
- Шилдэг үзүүлбэр тус бүр 1, 2, 3 дугаар байр эзлүүлэх ба үзүүлбэр тус бүрийн тэргүүн байрыг мөнгөн шагнал дагалдана.
- Шилдэг багаар 1, 2, 3 дугаар байрт шалгаруулж өргөмжлөл мөнгөн шагнал гардуулна.
- Шилдэгээр шалгарсан үзүүлбэр, хамт олны тоглолтыг нэгтгэн "Урлагийн наадмын шилдэг үзүүлбэрийн тоглолт-2019"-д оролцуулна.

Хянасан:

Боловсруулсан:

ОТХ-ийн дарга Д-р М.Эрдэнэчимэг

ОТХ-ийн мэргэжилтэн Л.Чинзориг

МУИС-ИЙН ХИЧЭЭЛИЙН 2-Р БАЙРНЫ УРЛАГ ЗААЛАНД БЭЛТГЭЛ ХИЙХ ЦАГИЙН ХУВААРЬ

Тавигдах шаардлага:

Анги, танхим, заал ашиглаж буй салбар сургуулийн хамт олон бэлтгэл сургуулилт хийх явцад бие даан хариуцах эзэнг тодорхой томилсон байх ба уг хариуцагч бэлтгэл сургуулилтын явцад заалны бүрэн бүтэн байдал, тог цахилгаан, техник хэрэгсэлийг хариуцан хүлээлгэн өгч байх шаардлагатай.

- Холбогдох хариуцагч, харуул, хамгаалалтын ажилтнаас анги, танхимыг хүлээн авч, үйлчлүүлэх хугацаа дуусмагц цэвэрлэн, анхны байдалд оруулан хүлээлгэж өгнө.
- Үйлчлүүлэгч сургуулийн анги, танхимын техник, хэрэгсэл, ширээ, сандал, цонх, хаалга, хана, бусад эд хогшлыг эвдэж гэмтээлгүй зүй зохистой ашиглана.
- Үйлчлүүлэгч техник, хэрэгслийг солих, шилжүүлэх, сургуулиас авч гарах, бүрэн бүтэн байдлыг өөрчлөн оролдохыг хориглоно.
- Үйлчлүүлэгч нь анги, тэнхимийг ашиглах хугацаанд гадны хүн оруулах, согтууруулах ундаа, тамхи хэрэглэх болон сургалт, эрдэм шинжилгээний үйл ажиллагаанд харшлах аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- Үйлчлүүлэгч холбогдох анги танхимын ашиглалтын дэвтэрт тухайн анги танхимыг хүлээн авсан болон хүлээлгэн өгсөн тэмдэглэлийг хийж хүлээлгэж өгнө
- Үйлчлүүлэгч сургуулийн дотоод журмыг баримтлан 21:00 цагаас хойш үйл ажиллагаа явуулахгүй байх.
- Эд хогшил, техник хэрэгсэл гэмтсэн тохиолдолд тухайн өдөр танхимд ажилласан тал хариуцан хохирлыг барагдуулна.
- Үйлчлүүлэгч дээрх зөрчлүүдийг гарган журмыг үл биелүүлэх тохиолдолд анги, танхимыг чөлөөлж өгөхийг шаардах эрхтэй.

- Үйлчлүүлэгч анги, танхимын техник хэрэгсэл, бусад эд хогшлыг өөрийн буруугаас эвдэж, гэмтээсэн тохиолдолд учирсан хохирлыг бүрэн хариуцна.

Цагийн хуваарь:

№	Сургууль	Өдөр	Цаг
1	ХЗС	2019.03.23	17:30-20:30
2	ОУХНУС	2019.03.24	17:30-20:30
3	БС	2019.03.25	17:30-20:30
4	ХШУИС	2019.03.26	17:30-20:30
5	ШУС-ХУС	2019.03.27	17:30-20:30
6	ШУС-НУС	2019.03.28	17:30-20:30
7	ШУС-БУС	2019.03.29	17:30-20:30

ЖИЧ: тавьсан шаардлагын дагуу салбар сургуулийн оролцогчид заал, танхимыг эмх цэгцтэй ашиглан хүлээлгэн өгөхийг хүсье.

Та бүхэнд амжилт хүсье.

МУИС-ИЙН ОЮУТАН, ТӨГСӨГЧИЙН ХЭЛТЭС